

Living the Lotus 6

Buddhism in Everyday Life

2025
VOL. 237



**2025 оны «Хойд Калiforniaгийн Интоор цэцгийн баяр»
РКК, Хойд Америкын гишүүд Сан-Франциско хотод болсон
баярын жагсаалд оролцов.**



Living the Lotus

Vol. 237 (2025.06)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын
хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

“Эцэг эхээ ачлах” гэдэг нь

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Өс санаж, дайсагнахгүй байх

“Эцэг эхээ ачлахсан, гэвч тэд үгүй. Одоо чулуу (булш)-г нь хөнжлөөр хучаад яалтай.” гэдэг зүйр үг бий. Энэ үгийг сонсоод эцэг эхээ амьд сэрүүн байхад нь ачлахгүй яав даа хэмээн харуусаж, “Нээрэн л тийм дээ” гэж толгой дохих хүн олон байгаа болов уу. Хэдий “Чулууг нь хөнжлөөр хучаад яалтай.” гэж бичсэн байгаа ч, одоо юу ч хийгээд нэмэргүй, хийх шаардлагагүй гэсэн үг биш.

Өмнөх сарын дугаарт дурдсанчлан бидний амь нас сансар огторгуйн үүсэлтэй холбоотой ба ийм агуу амь насны түүхийн явцад нэг ч тасраагүй амь насны гинжин холбооны ачаар өнөөдөр бид амьдардаг. Тэр утгаараа эцэг эх, өвөг дээдсээрээ дамжуулж өөрийн амь насны эх үндсийг тунгаан бодож, ирээдүйн төлөө одоо би юу хийж чадах вэ гэж өөрөөсөө асуух нь эцэг эхээ ачлахын утга учрыг эргэцүүлэн бодож байна гэсэн үг болно.

Мөн “ачлах” гэсэн утгатай ханз нь “настан”, “хүүхэд” гэсэн хоёр ханз үсэгнээс бүтдэг ба өвгөд хөгшид, залуу үеийн залгамж холбоо тасралтгүй үргэлжилсээр үеэс үе дамжин өвлөгдөх нандин чухал зүйлээр холбогдон нэгддэг гэсэн утга агуулагддаг. Тэгэхээр эцэг эхээ ачлах гэдэг нь аав ээжээ асран халамжлахаас хавьгүй гүнзгий утга агуулгатай болох нь гарцаагүй болж таарч байна.

“Күнзийн сургаал”-д “Эцэг эхээ ачлах гэж юу гэсэн үг вэ?” гэж асуухад Күнз “Эцэг эх гагц үр хүүхдийнхээ өвчин зовлонд л шаналдаг” гэж ойлгомжтой хариулсан байдаг. Энэ нь эцэг эх хүн үргэлж үр хүүхдээ эрүүл саруул яваасай гэж боддог тул өөрийн биед анхаарч, тэдний сэтгэлийг зовоохгүй байх хэрэгтэй гэсэн үг ба мэдээж хэрэг энэ ч гэсэн чухал. Энд гарч буй “өвчин зовлон” гэсэн утгатай ханзанд “өс санах, үзэн ядах, атаархах, зовоох” гэсэн утга ч байдаг. Ясүока Масахиро (1898-1983) гуайн судалгаанаас үзсэн ч гэсэн “өвчин зовлон гэдэг ханзанд дайсагнал гэх утга бий” гэж бичжээ.

Тэгэхээр эцэг эхтэйгээ харилцах харилцаа төдийгүй аливаа хүний харилцаанд хувийн хүсэл шунал, хэрүүл тэмцлийн улмаас хагарал үүсгэхгүй байхын төлөө өөртөө анхаарч явах нь бидний өдөр тутамдаа хийж чадах эцэг эхээ ачлах үйлийн нэг болох юм.



Эцэг эхээ үл ачлах нь амь таслахтай ижил нүгэл

Ядуу буурай хүмүүст тусалж, үер усны хамгаалалт хийн олонд бодисадва хэмээн хүндлэгдсэн Гёоки хувраг (668-749)-ын “Тургуул шувуу шагшран жиргэх ахуйд аав, ээж минь үү дээ гэж бодогдоно.” гэх шүлэг бий. Насан өөд болсон эцэг эхээ санан дурсах өнгө аяс шингэсэн, гургуулын жиргээн хүртэл эцэг эх нь дуудах мэт сонсогдоно гэсэн утгатай шүлэг. Энэхүү харуусал гуниг нь сэтгэл зүрхийг эмзэглүүлнэ.

Бид ийнхүү энэлэн шаналах үе байдаг ч заримдаа төрүүлсэн эцэг эхдээ баярлаж талархахаа умартаж, царай төрхөө голон гомдоллож, санаснаар болохгүй амьдралаа үзэн ядах нь олонтой. Хүртсэн амь насандаа талархалгүй байна гэдэг нь эцэг эхээ үл ачилж буйтай агаар нэг бөгөөд буддын Соото урсгалын Ёго Сүиган (1912-1996) багш үүнийг “амь хөнөөх нүгэл” гэж хэлсэн байдаг. Ёго багштан “агуу уудам орчлонгийн амь”-ын нэг хэсэг болон амьдарч буй бид, өөрөөр хэлбэл бурханлаг мөн чанарыг тээсэн хүмүүний амьдрал бол бүгд юутай ч зүйрлүүлэшгүй нандин гайхамшигтай бөгөөд учир утгагүй амьдрал, хэрэггүй амь гэж энэ орчлонд нэгээхэн ч үгүй гэж онцлон сургасан. Тийм байтал өөрийгөө, өөрийн амьдралаа “шүүх” нь амь насныхаа эх үндсийг үгүйсгэж байгаатай утга ижил. Өөрөөр хэлбэл эгэл сүсэгтэн хүний баримтлах ёстой таван сахилын нэг амь үл хөнөөх нүглийг үйлдэж байна гэсэн үг гэж сургажээ.

Энэ утгаараа үргэлж уурлаж ундуйцан, гомдоллож байдаг “эго”-оо аль болох дарж, бусадтай дайсагнахгүй, өөрийн бурханлаг чанарт итгэж, аливаа зүйлийг Бурханы таалал (туйлын үнэн)-ий дагуу байгаагаар нь хүлээж авах нь хүмүүс бидний хувьд эцэг эхээ ачлах үйл юм. Түүнчлэн агуу байгаль дэлхийн хууль нь өсөн дэвшиж урагш ахих, шинийг бүтээх гэсэн гол зарчимтай байдаг ба хүн төрөлхтөн ч гэсэн үүнд хамаатай. Тиймээс бид өөрсдөө өсөж хөгжихийн зэрэгцээ ирээдүйг бүтээх “хүн бэлдэх” нь ч гэсэн бидний чухал үүрэг болох юм. Энэ ч гэсэн ирээдүй рүү үргэлжлэх амь насыг бэлдэх гэдэг утгаараа эцэг эхээ ачлахтай холбоотой гэж бодож байна.

Үүний тулд нэн чухал зүйл бол “өөртөө шударга, бусдад энэрэнгүй байх” гэсэн хандлага ба энэ нь дээр өгүүлсэн зүйлсэд бүгдэд нь хамаатай. Уучлах, хүлээн зөвшөөрөх, чин сэтгэлээ зориулах, бусдыг бодох эдгээрийг өдөр тутамдаа хэрэгжүүлснээр эв нэгдэл хэмээх эрхэм чухал үзэл санаа жинхэнэ утгаараа нийгэмд түгэж, ирээдүй хойч үед залгамжлагдан үлдэх юм.

«Косей» сэтгүүл, 6-р сарын дугаараас



Spiritual Journey

Бурханы сургаалаар гэрэлтэж, хүмүүсийн тусын төлөө зүтгэнэ

Монголын РKK, Эрдэнэт хэсэг Гөлгөөгийн Мядагмаа

Энэхүү илтгэл нь 2025 оны 3-р сарын 15-нд Шагжамүни бурхны амин өдрийн ёслол дээр тавигдсан болно.

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Миний бие 1959 онд эгч дүү арван хүүхдийн ууган хүүхэд болж мэндэлсэн. Эцэг эх маань төмөр замын өртөөнд ажилладаг байсан тул бид өртөө дамжиж их нүүдэг байсан. Эцэг эх маань өглөө гараад орой ирдэг ажилтай тул миний хувьд эцэг эхийгээ орлон дүү нарыгаа харж хандан, гэр орны ажлаа хийн тун завгүй байсан боловч олуулаа бужигнасан хүүхэд насны амьдрал маань аз жаргалтай өнгөрсөн. Багаасаа олон дүү нартай байсан болоод ч тэр үү хүүхдүүдтэй ажиллах ажил мэргэжил эзэмшихийг хүсдэг байсан ба багш юм уу эмч болох мөрөөдөлтэй байв.

Аав маань хүнд их тусархуу, туслахдаа огт хариу нэхдэггүй хүн байсан. Ээж маань хүмүүст илүү гарсан хоол хүнсээ үргэлж хуваалцдаг өглөгч хүн. Аав маань хүнд өвчний улмаас 45 хан насандаа бурхан болсон. Ээж маань одоо 87 настай, эрүүл саруул аж төрөн амьдарч байна.



Мядагмаа гишүүн Их ариун ордонд
илтгэл тавьж байгаа нь



1991 он, Гэр бүлийн дурсгалын зураг

Хүүхдүүддээ одоо хэрнэ дээл оёж бэлэглэдэг, сургаалаа айлддаг, бидний чиглүүлэгч юм. Уржнан жил ээжийнхээ 85 насны ойг тэмдэглэхэд эцэг эх хоёулхнаа үүсгэсэн гэр бүл нь ач зээ, бэр хүргэн бүгд ороод 108 гишүүнтэй болж өргөжсөн байсан.

Би 1982 онд Улаанбаартар хотын Анагаах ухааны их сургуулийг хүүхдийн эмч мэргэжлээр төгсөж мөрөөдөл минь биелэсэн. Дараа нь нөхөртэйгөө танилцаж, 1985 онд охиноо, 1989 онд

Spiritual Journey

хүүгээ төрүүлсэн. Гэвч үзэл бодол нийлэхгүй, нөхөр гар хүрдэг болсон тул 7 жилийн дараа салж, аль болох хол байхыг хүсэн хоёр хүүхдээ аваад Монголын 2 дахь том хот болох Эрдэнэт рүү нүүж, тэнд Эрдэнэтийн төмөр замын эмнэлэгт өрхийн эмчээр ажиллаж эхэлсэн.

Ийнхүү ажиллаж байхдаа хоёр дахь нөхөртэйгөө танилцсан ба зөөлөн сэтгэлтэй, халамжтай нэгэн байсан. Хоёр хүүхдэд маань халамжтай сайн аав нь болж чадсан. Анхны гэрлэлтээс маань тэс өөр амар амгалан, аз жаргалтай амьдарсан.

Яг тэр үед нэг танил маань хамт наймаа хийе гэсэн юм. Үр хүүхдийнхээ ирээдүйд тус нэмэр болох хүсэлтэй миний хувьд илүү орлого олохыг хүссэн боловч наймаа маань санаснаар болохгүй дампуурч, хүнд хууртагдаж, өр зээлэнд орсон. Энэ амаргүй цаг үед сүүлд суусан хань маань өвчний улмаас 2005 онд бурхан болсон. Ингээд үр хүүхдээ сургаж хүмүүжүүлэх, гэр орноо авч явах, өр зээлээ дарах зэрэг амаргүй ачааг ганцаараа үүрэхээс өөр аргагүй болсон. Аз жаргалтай сайхан амьдрал маань орвонгоороо эргэсэн юм шиг л санагдсан.

Нөхрөө нас бараад удаагүй байхдаа номын замд хөтлөн оруулсан УБ хотод амьдардаг Энхтуяатай танилцсан билээ. Тэр хүнээс анх Монголын Рисшо Косей Кай нийгэмлэгийн талаар сонссон. Монгол хэл дээр хөх өнгийн судар уншдаг, эх дэлхийгээ хайрлая, эцэг эхээ



Судар уншлагад оролцсон гишүүдийн хамт



*2018 он, Эрдэнэт хэсгийн
Бурхан залах ёслолын дараа*

хайрлая, бусдыг хайрлая гэж сургадаг гэж хэлсэн. Энэ үг нь надад их таалагдаж, очиж үзэх хүсэл төрүүлсэн. Ингээд 2006 онд Рисшо Косей Кай нийгэмлэгийг зорин очсон юм. Тэр үед байрны жижиг өрөөнд Зоригмаа тэргүүнийг оролцуулаад 5 эмэгтэй монгол хэл дээр судар уншиж байсан. Надад бас судар өгөөд бид хамт уншсан. Судрыг уншиж байх явцад Арван буян бүлэг дээр гардаг арван хар нүгэл үйдэгчдэд арван цагаан буяны сэтгэлийг төрүүлэх хэсэг гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн. Тэр үед би өр зээлээ төлөхийн төлөө ухаан жолоогүй байснаас үр хүүхдэдээ анхаарал халамж бүрэн тавьж чадаагүйдээ өөрийгөө зэмлэж байсан юм. Тиймээс би ийм ариун нандин судрыг өдөр бүр унших юм бол сэтгэл ариусах юм байна, мөн сэтгэл нь бохирдоогүй хүүхдүүд багаасаа уншаад сурчихвал бүр илүү үр дүнтэй юм байна гэсэн бодол төрөв. Судраа уншиж дуусаад хооза дээр төрсөн сэтгэгдэлээ хуваалцаж, Эрдэнэтийн хүүхдүүдэд судрыг уншуулмаар байгаагаа хэлсэн.

Ингээд 2 сарын дараа Зоригмаа тэргүүн 5 хүний бүрэлдэхүүнтэй Улаанбаатар хотоос сургаал түгээхээр ирсэн. Бид төмөр замын хурлын заалыг бэлдэж, 20 гаруй хүүхэд, 6 насанд хүрэгчдийг цуглуулан хүлээж авсан. Нөгөөдөр нь манай гэрт ирж Эрдэнэт хэсгийн Бурханыг залж, судар уншсан. Номонд дээрх 20 орчим хүүхэд, томчууд бас оролцсон. Зоригмаа тэргүүн 21

Spiritual Journey



2018 он, Эрдэнэт хэсгийн бурхан залах ёслолын дараа (Зүүн талаас Саитоо дарга, Мядагмаа гишүүн, Хиросэ дэд дарга)

хоногийн турш судраа таслалгүй уншвал хүсэл нь биелнэ гэж хэлсэн юм. Тэр өдрөөс хойш би гэртээ 21 хоног судраа таслахгүй унших зорилго тавьж, орой бүр 7 цагаас судраа уншиж байв. Бурхан залах үед байсан хүүхдүүд, томчууд ч гэсэн номонд идэвхтэй оролцож байсан. 21 хоног судар унших нь сургаал номыг ойлгуулах уран арга байсан боловч шинээр ирсэн хүмүүс 21 хоног уншина гэж ар араасаа нэмэгдсээр нэг мэдэхэд 3 сарын турш орой бүр манай гэрт судраа уншсан байсан. Судар уншлагад тогтмол оролцоод хүмүүсийн сэтгэл ариусч, түүнээс үүдэн гарч байгаа эерэг өөрчлөлтүүдээ хүмүүс номын дараа ярьдаг байсан. Гэр бүл салах гэж байсан эхнэр нөхөр хоёр эвлэрсэн, нөхөр нь архи уухаа больсон зэрэг олон эерэг өөрчлөлтүүд гарсан. Ийнхүү Эрдэнэт хэсгийн сургаал түгээлт манай гэрт 3 жил тасралтгүй үргэлжилсэн.

Миний хувьд ч гэсэн судар уншлагаар дамжуулж олон зүйлийг анзаарч, ухаарсан. Би анхны нөхрийнхөө тухай бодохыг ч хүсдэггүй байсан. Гэвч сургаалын ачаар тэр хүний талаар, мөн өөрийнхөө талаар дахин эргэцүүлэн бодож, бид учрах ёстой байсан юм байна гэж харах өнцөг маань өөрчлөгдсөн. Би өөрөө ч гэсэн нөхөртэйгөө учрахаас өмнө хүмүүсийн сэтгэлийг эмзэглүүлж,

гомдоож байснаа ухаарсан. Үүнийг ухааруулахын тулд Бурхан намайг нөхөртэй маань учруулсан юм байна гэж бодсон. Улмаар тэр олон жил надаар үзэн ядуулж байсан нөхрөө өрөвдөх сэтгэл төрсөн. Харах өнцөг өөрчлөгдсөнөөр сэтгэл ч гэсэн өөрчлөгддөг болохыг эндээс гүнзгий мэдэрсэн юм.

2008 онд шүнин буюу хэсгийн ахлагчийн үүргийг авсан. Гишүүдийн тоо ихэссэн тул хотын төвд байр түрээсэлж, хэсгийн үйл ажиллагаагаа явуулах болсон. Би маш их эрч хүч, баяр хөөр дүүрэн салбар дээрээ очиж, гишүүдтэйгээ судар номоо уншиж, сургаалаа түгээдэг байсан. Түүнчлэн гэр бүл, найз нөхөд, хамт ажиллаж суралцаж байсан хүмүүсээ гишүүн элсүүлж, бусад хөдөө орон нутагт сургаал түгээн, үйл ажиллагаагаа танилцуулж байсан. Одоо элсүүлсэн гишүүдийн тоо 240 орчим болжээ. Косей кай нийгэмлэгтэй учирснаар миний амьдрал өөрчлөгдсөн. Судраа уншиж, сургаалаас суралцах тусам надтай учрах учралууд намайг илүү хөгжүүлэх гэсэн Бурханы нигүүлсэхүй юм байна гэж хүлээж авдаг болсон.

Ийм сэтгэлтэй болоход нэг үйл явдал хүчтэй нөлөөлж, надад сэтгэлийн хат суулгасан гэж би боддог. 2014 онд зээ хүү төрсөн тул УБ хотод ирж зээ хүүгээ харах шаардлагатай болсон. Тиймээс би Эрдэнэт хэсгийн ахлагчийн үүргийг түр хугацаагаар өөр гишүүнд даатгаад хот явсан юм. Жил орчмын дараа хэсэг дээрээ ирэхэд түр үүрэг даатгаж



2018 он, Номын багш цол гардуулах ёслолын дараа Монгол гишүүдийн хамт

Spiritual Journey

үлдээсэн хүн маань хэсгийн ахлагч болсон байсан. Миний хувьд ахлагчийн үүрэг гэнэт өөрчлөгдсөнд их цочирдож хүлээж авсан. Эрдэнэт хэсэг байгуулагдсан цагаас хойш чадах ядахаар хичээсэн байхад яагаад надтай зөвлөлдөхгүй үүргээс буулгадаг байнаа гэж гомдсон. Ийм ойлгомжгүй нөхцөл байдал хэсэг хугацаанд үргэлжилсэн ба үр дүнд нь сургаал номондоо дур сонирхолгүй болж, судраа ч талархсан сэтгэлээр уншиж чадахгүй байдалд хүрсэн. Ерөнхийдөө сургаал номноосоо хөндийрсөн цаг үе 3 жил үргэлжилсэн. Сэтгэл санаа байнга тухгүйдэж, гомдсон сэтгэл маань арилахгүй байсан.

Нэг орой наминчлах судрыг уншиж байтал энэ бүхний шалтгааныг яагаад би өөрөөсөө хайгаад үзэж болохгүй гэж гэсэн бодол төрсөн. Болсон нөхцөл байдлын шалтгааныг өөрөөсөө хайгаад бодоод үзэхэд, “би эрдэнэт хэсгийг үүсгэн байгуулсан гэсэн омог бардам зан, атаархах сэтгэлд хамаг учир байсныг ухаарсан. Зовлонгийн шалтгаан “би хэнээс ч илүү хичээсэн, миний зөв бусын буруу” гэсэн аминч үзэлд байсныг ухаарсан. Яг л арван хар нүгэл үйлдэгчдэд арван буяны сэтгэлийг төрүүлмүй хэмээх сургаал мэт энэ зовлон бол омог бардам намайг ухааруулах Бурханы агуу нигүүлсэхүй байсан юм байна гэж бодогдсон. Бурханы ач ивээлийг олж харснаар нүд нээгдэх шиг болж, бүх бие баяр хөөрөөр дүүрэх шиг мэдрэмж төрж, бүх зүйл гэрэлтэж харагдсан. Маргааш нь Эрдэнэт хэсэг лүүгээ яаран яаран очиж, гишүүддээ өөрийн сэтгэлийн гэмийг олж харсан талаараа ярьж, сэтгэлээ наминчилсан. Тэр үед намайг халуун дулаан сэтгэлээр ойлгож хүлээж авсан номын анд нөхөддөө чин сэтгэлээсээ талархаж байна.

2018 онд Эрдэнэт хэсгийг төв албан ёсны хэсгээр бүртгэн авч, Эрдэнэт хэсэгт төвөөс тухайн үеийн ОУХ дарга Сайто, Хиросэ тэргүүн нар ирж Дүрст бурхан залсан. Тэр өдөр Хиросо дарга намайг

дуудаж уулзаад номын багшийн эрх авах санал тавьсан. Би ч тэр дороо баяртайгаар хүлээн авсан. Ийнхүү өөрийнхөө алдаа дутагдлыг ойлгож, наминчилснаар Бурхан бодож ч байгаагүй бэлгийг надад өгсөн юм.

2020 онд би элэгний хорт хавдартай гэж оношлогдсон. Гайхалтай нь хорт хавдар гэдэг оношийг сонсоод миний хувьд айж сандраагүй. Элэгний дөрвөн хэсэгт хавдар илэрсэн тул элэгний ихэнх хувийг тайрах амаргүй хагалгаа хийлгэх шаардлагатай болсон. Яг тэр мөчид номын андууд маань миний эрүүл мэндийн төлөө бүтэн өдөр бүр төв дээр Лянхуан Гурамсан судрыг бүтэн сарын турш уншсан. Номын андуудынхаа халуун сэтгэлд нь маш их талархаж, эрч хүч авсан. Номын ач буянаар надад энэ бүхнийг даваад гарч чадна гэсэн итгэл төрж, урт насалж цаашид ч гэсэн олон хүнд туслах юмсан гэж бодсон. 2021, 2023 онд хавдар дахисан тул дахиад мэс засалд орсон. Тэр болгонд сургаалын ачаар сэтгэлээ тайван байлгаж, даван туулж чадсан. Саяхан бас дахиж сэдэрсэн тул эмчилгээ хийлгэсэн. Гэсэн хэдий ч айж эмээх зүйлгүй, сэтгэл санаа амар амгалан байж чадсан. Хэрвээ би бурхны сургаалтай учраагүй байсан бол эмч хүнийхээ хувьд гарч болох эрсдлүүдийг илүүтэй анхаарч хавдраа даамжруулах байсан болов уу. Гэхдээ өнөөг хүртэл тохиолдсон зовлон бэрхшээлийн ачаар бүх зүйлийг тайван хүлээж авч чаддаг болсон.

Одоо ч гэсэн надад хийхийг хүссэн зүйл бий. Аль болох олон хүнд туслах юмсан, түүний тулд жаахан ч гэсэн урт наслах юмсан гэж бодож байна. Мөн коронагийн улмаас үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон Эрдэнэт хэсгийнхээ үйл ажиллагааг тогтворжуулахын төлөө, хүн бүхэн эрүүл энх, амар амгалан байхын төлөө цаашид ч гэсэн сургаал номоо хичээнгүйлэн түгээх болно.

Анхаарал тавин сонссон та бүхэнд баярлалаа.

Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Рисшо Косей Кай нийгэмлэгийн байгууламж

Их Ариун Ордон

Тус байгууламжийг гишүүдэд зориулсан залбирал номын танхим болгон 1964 онд барьж, Гол шүтээн (Ялж төгс нөгчсөн дуусахгүй буян үйлдэгч номын хаан Шагжамүни)-ийг залсан.


Цагаан Лянхуа судрыг “өөгүй дугуй сургаал” гэж хэлдэг учраас энэхүү ордныг дугуй хэлбэртэй барьсан ба тойрсон найман цамхаг нь “Хутагтын найман мөр” сургаалыг

илэрхийлдэг.

4-р давхарт Гол шүтээн бүхий танхим, 5-аас 7-р давхарт номын хурлын суудлуудтай.

2-р давхарт хоолны газар, 7-р давхарт “Бясалгалын өрөө” байдаг.

2006 онд газар хөдлөлтөөс хамгаалах засвар хийж шинэчилсэн.




Бяцхан мэдлэг

Их Ариун Ордоны гол хаалган дээр гурван бодьсадвагийн хөрөг өлгөөтэй байдаг ба дараах утгатай. Зүүн талаас:
Манзушир – Бэлгэ билгүүн
Хотолд сайн – Үйлдэл, хэрэгжүүлэх
Майдар – Энэрэл нигүүсэл

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Нийгэмлэгийн анхны төв, мөргөлийн дуган



Бяцхан мэдлэг

Үүсгэн байгуулагч, Мёокоо багштаны хүрэл хөшөөг 1987 онд тус анхны төвийн дурсгалын самбарыг байрлуулах үед хамт босгосон.

Мөргөлийн дуганд мөргөхөөр ирэх үедээ хашаан дотуур алхангаа нийгэмлэг анх үүсгэн байгуулагдаж байсан үетэй танилцаарай.

Их Ариун Ордон баригдахаас өмнө төв байр байсан газрыг Рисшо Косей Кай нийгэмлэгийн анхны төв, мөргөлийн дуган гэж нэрлэдэг.

1948 оны 12-р сард 170 цүбо буюу 562мкв газарт 100 татами (81см×162см хэмжээтэй сүрлэн шал) талбайтай мөргөлийн дуганыг барьсан бөгөөд тэр чигээрээ гишүүдийн сайн дурын хүч хөдөлмөрөөр боссон. Үүсгэн байгуулагч өөрөө ч шороо зөөж, хөлсөө дуслуулан зүтгэсэн гэдэг.

Энэхүү нийгэмлэгийн анхны төвд мөргөлийн дуганаас гадна Үүсгэн байгуулагч, Мёокоо багштаны хүрэл хөшөө, мөн Мёокоо багштаны амьдарч байсан гэр байдаг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Хол байгаа ч эцэг эхийн ачийг
хариулах боломж бий

Акагава Кэйичи

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. 6-р сар болж нэг жил хэдийн талдаа оржээ. Токио хотод хавраас зун руу шилжиж борооны улирал эхлэх дөхөж байна.

Энэ сарын ерөнхийлөгчийн айлдвар “Эцэг эхээ ачлах гэдэг нь” гэсэн сэдэвтэй байлаа. Энэ бол надад бага зэрэг сэтгэлийн зовиуртай сэдэв л дээ. Яагаад гэвэл би Акита мужаас Токиод ирж амьдраад аль хэдийн 39 жил өнгөрчээ. Энэ хугацаанд хэвтэрт байсан аавыг маань эцсийн мөч хүртэл асарч халамжилсан хүн бол миний том эгч, түүний гэр бүл байсан юм. Энэ жил 90 нас хүрч буй ээжийг маань мөн адил том эгч асарч байгаа.

Ээжид бага зэрэг зөнөх өвчний шинж тэмдэг илэрч элдэв бэрхшээл байсан ч одоо бол тогтмол эмчийн үзлэгт орж, өдрийн асаргааны үйлчилгээ авч, гэртээ тайван өтөл насаа өнгөрүүлж байна.

Өнгөрсөн оны сүүлчээр аавынхаа 13 дахь хойтын буяны ёслолоор нутагтаа очих үед, 40 гаруй насны зээ дүү маань надад ингэж хэлж билээ.

“Эмээ таныг утсаар ярьсан өдөр илт өөр болчихдог. Тэр өдөржингөө царай нь гэрэлтээд, эрч хүч нь сэргээд баяр баясгалантай байдаг. Тийм болохоор ачийг нь хариулж байна гэж бодоод ойр ойрхон ярьж байвал тус болно шүү.”

Ээж минь хүчтэй зоригтой нэгэн боловч хөгшрөхийн хэрээр өөрийн тааваар байж чадахгүй, сэтгэлийн зовиуртай байгаа гэдгийг зээ дүүгийн үгнээс ойлгосон юм. Ээжээсээ хол амьдарч байгаа ч сэтгэлийг нь жаахан ч болов ойлгож, Нивано ерөнхийлөгчийн айлдсан “Өөртөө хатуу, бусдад энэрэнгүй” байхад өдөр бүр чин сэтгэлээсээ хичээж явах болно.




4-р сарын 29, Тайнан салбарын айлчлалаар

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp